

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2020 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН  
ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН

2020 оны 04 дүгээр сарын 02

Багануур дүүрэг

Хууль тогтоомж		Нийт	МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		3						3					
Хяналтад авсан нийт зүйл заалтын тоо		9						9					
Бүрэн хэрэгжсэн	100%	9											
Хэрэгжих шатанд	70%												
Хэрэгжилт хангалтгүй	30%												
Хэрэгжээгүй	0%												
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй													
Биелэлтийн дундаж %		100											

ДҮГНЭСЭН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА

Ч.ЭЛБЭГСАЙХАН



ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2020 оны 04 дүгээр сарын 02

Багануур дүүрэг

**Нэг.** Хяналт шинжилгээ үнэлгээний зорилго

Тогтоол шийдвэрийн нэгдүгээр улирлын хэрэгжилтийг төлөвлөсөн зорилт, хүрэх түвшинтэй харьцуулж, үр дүнг үнэлэн, зөвлөмж дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангахад оршино.

**Хоёр.** Хяналт шинжилгээ үнэлгээний арга зүй

Зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээн хийх” нийтлэг журмын 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг удирдлага болгов.

**Гурав.** Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Тогтоол шийдвэрийн нэгдүгээр улирлын хэрэгжилтэд 9 ажил тусгагдсан бөгөөд хяналт, үнэлгээг хүснэгтээр харуулбал.


Зорилт	Үйл ажиллагааны биелэлт хувиар						Дундаж хувь
	0%	30%	70%	100%	Хамааралгүй заалт	Үнэлэх боломжгүй	
100	0	0	0	9	0	0	100%


**Дөрөв.** Дүгнэлт

Тогтоол шийдвэрийн нэгдүгээр улирлын хэрэгжилтэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 100 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн ба захиргааны албыг цаашид хэрэгжилтийг дахин бүрэн хангаж ажиллахыг үүрэг болголоо.

**Тав.** Зөвлөмж

Шинэ коронавирусийн халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дээд шатны байгууллагаас ирсэн тогтоол, захирамж, шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллах, тайлан мэдээг үнэн зөвөөр бэлтгэн гаргаж холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлж ажиллах

ТАЙЛАН ХЯНАСАН:  
“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА  Ч.ЭЛБЭГСАЙХАН

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ХУУЛИЙН ЗӨВЛӨХ  С.ОТГОНБААТАР



**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ  
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2020 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2020 оны 04 дүгээр сарын 02

Багануур дүүрэг

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо /дугаар, агуулга/	Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь	Үнэлгээний хувь	Үнэлгээ, /хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал/	Тасарсан болон удаширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6	7	8
Салбар чиглэл: 1							
1.е. Засгийн газрын тогтоол							
1.	1.2.	2018.08.22 №258 Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай  Иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх;	<ul style="list-style-type: none"> <li>Иргэдээс байгууллагад гаргасан хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдол байхгүй болно.</li> <li>Байгууллагын удирдлага иргэд, ААНБ-ын санал хүсэлтийн дагуу хүлээн авч уулзаж, зөвлөгөө өгч дэмжин ажиллаж байна.</li> </ul>	100%	100%		
	1.4.	Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох	Сул орон тоо гарахад үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилж ажиллуулсан.	100%	100%		

2.	11	<p>2020.01.26 №30 Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай</p> <p>Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар өөрийн байгууллагадаа ухуулга, сурталчилгаа хийх, ажилтнуудын дархлааг дэмжих, амны хаалт хэрэглэх, гар угаах болон халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг бүх шатны төрийн байгууллагын дарга, захирал нарт даалгаж, хувийн хэвшлийн байгууллагын ажил олгогч нарт уриалсугай.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Томуу, томуу тест өвчлөлт болон шинэ корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, ажилчдын дархлааг сайжруулах зорилгоор дотооддоо 02 дугаар сард “Халуун аарц” аян өрнүүлж ажилласан.</li> <li>• Албан хаагчдын амны хаалтын хэрэглээг хэвшүүлэн, ажилчдыг N95 амны хаалт, нэг удаагийн бээлий, Паркийн нэгж болох Монхимо ХХК-ийн амны хаалт, гар халдваргүйжүүлэх нөхцөлөөр ханган, байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээний материал, ариутгалын бодис зэргийг хангалттай нөөцлөн, өглөө бүр ажлын байранд чийгтэй цэвэрлэгээг хийж, хаалганы бариулыг 2 цаг тутамд спиртээр ариутгаж байна.</li> <li>• ЭМЯ болон дүүргийн ЭМТ-өөс өгч байгаа зөвлөмж, корона вирусын халдвараас урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл, цаг үеийн мэдээг өглөө бүр албан хаагчдад танилцуулан, мэдээллийг <a href="http://www.baganuur-itp.mn">www.baganuur-itp.mn</a> цахим хуудсанд тогтмол байршуулж байна.</li> </ul>	100%	100%		
3.	2	<p>2020.02.12 №62 Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай</p> <p>Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан 17 дугаар жарны Хотол төгс хэмээх төмөр хулгана жилийн Цагаан сарын баярыг тэмдэглэхгүй байх нь зүйтэй гэж үзсүгэй.</p>	<p>Албан хаагчид 17 дугаар жарны Хотол төгс хэмээх төмөр хулгана жилийн Цагаан сарын баярыг зөвхөн өөрсдийн гэр бүлийн хүрээнд тэмдэглэсэн болно.</p>	100%	100%		



1.7.	Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох;	Байгууллагын дотоод журамд тусгасан бөгөөд одоогоор зөрчил гаргасан тохиолдол байхгүй байна.	100%	100%		
1.8.	Төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;	Зөрчил гаргасан тохиолдол байхгүй.	100%	100%		
1.9.	Төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах;	Байгууллагын цаг бүртгэлийг 2019 оны 2 дугаар сараас эхлэн хурууны хээний машинаар бүртгэж, түүнд хяналт тавин ажиллаж байна.	100%	100%		
9.1	Нийслэлийн дотоод удирдлагын "UB ERP" системийн цаг бүртгэлийн дэд системд холбогдох тухай	"Монголын цахилгаан холбоо" ТӨХК-аас IP эрх авч байгууллагын цаг бүртгэлийн төхөөрөмжийг "UB ERP" системийн цаг бүртгэлийн дэд системд 2019 онд холбосон. Нийслэлийн "UB ERP" системийг байгууллагын дотоод удирдлагын үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж, албан хаагчдын хэрэглээг жигдрүүлсэн. Мөн байгууллагын хүний нөөцийн мэдээллийг системд үнэн зөв оруулж, мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрд шинэчлэн ажиллаж байна.	100%	100%		

	3	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж"-ийн дагуу хэрэгжүүлэн ажиллахыг гамшгаас хамгаалах алба, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.	Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд шинэ корона вирустэй холбоотойгоор нэмэлт заалт оруулан тодотгол хийж албан хаагчдад танилцуулсан.	100%	100%		
		Хэсгийн дундаж		100%	100%		
		Нийт дундаж		100%			

ТАЙЛАН ХЯНАСАН:  
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН:  
ЗАХИРГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

*Laswit*

Б.НОМИНЗУЛ



**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”  
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2020 оны 02 дугаар сарын 21

№01

Багануур дүүрэг

Хурал 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр 09:40 цагт “Багануур Үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын дарга Ч.Элбэгсайханы ажлын өрөөнд эхлэв. Хуралд Газрын дарга Ч.Элбэгсайхан, Захиргааны ахлах мэргэжилтэн Б.Номинзул, Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтэн Д.Алтангэрэл нар оролцов.

**ХЭЛЭЛЦСЭН нь:**

1. Нийслэл, дүүргийн шуурхай хуралдаанаас авсан болон цаг үеийн чанартай мэдээлэл хүргэх
2. Байгууллагын дүрэм, БҮТП-ийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг шинэчлэх талаар хэлэлцэх

**СОНССОН нь:**

**Ч.Элбэгсайхан /Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын дарга/:**

Өглөөний мэнд! Шуурхай хуралдаанаар дэлхий нийтийг хамарсан шинэ коронавирусын халдвар дэгдсэнтэй холбоотойгоор Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, нийслэлийн Засар даргын захирамжууд, Онцгой комиссоос гарсан шийдвэрүүдийг танилцуулсан. Та бүхэн бас мэдээлэл сайтай л байгаа.

Голлож юу ярьж байна гэхээр хот руу орж байгаа хөдөлгөөнийг зогсоож, тээврийн хэрэгсэл дотор байгаа бүх хүнийг шалгаж, халууныг нь хэмжих, сэжигтэй тохиолдолд арга хэмжээ авч тусгаарлах зорилгоор бүх постууд дээр Онцгой байдал, эрүүл мэнд, мал эмнэлэг, мэргэжлийн хяналт зэрэг байгууллагуудаас Цагдаагийн байгууллагатай хамтарсан 24 цагийн эргүүл, шалгалт хийгдэж байгаа. Давхар хяналт шалгалтууд явагдаж байгаа учраас өөр бусад зөрчлүүд бас илэрч байгаа юм байна. Бичиг баримтгүй буу зэвсэг тээвэрлэх, ховор амьтны мах, арьс үс тээвэрлэх, мөн контрбанд маягийн зөрчлүүд нэлээн илэрч байгаа гэж байна. Тэгэхээр энэ хяналт, шалгалтууд зөвхөн чиглэсэн арга хэмжээ бус олон талт үйл ажиллагаа болж үр дүнгээ өгч байна гэж дүгнэж байна. Аптекуудад хомсдол их үүссэн, маск бүр байхгүй болсон, янз бүрийн вирусын гаралтай өвчнүүдийн эм тарилга нэлээн ховордож хомсдол үүссэн байна. Зах худалдааны төвүүдийг хаахгүй. Тогтоол, шийдвэрүүдийг хүн бүр хэрэгжүүлж ажиллах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ маш сайн авах, хариуцлагатай байх хэрэгтэй. Өөрсдийгөө хамгаалахад маскны хэрэглээ, гараа тогтмол угааж ариутгах нь маш чухал. Өндөржүүлсэн бэлэн байдлыг 03 дугаар сарын 30 хүртэл зарлачихсан. Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 12–ны Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 62 дугаар тогтоолд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан 17 дугаар жарны Хотол төгс хэмээх төмөр хулгана жилийн Цагаан сарын баярыг тэмдэглэхгүй байх нь зүйтэй гэж үзсэн байна. Цагаан сарыг гэр бүлийн хүрээнд цомхон, болж өгвөл тэмдэглэхгүй байхыг албаны албан хаагчиддаа сайн анхааруулж сануулаарай. Аль болох баяр наадам тэмдэглэхгүй, халдвар гарсан улс орноор зорчихгүй, олон хүн цугласан газар очихгүй байх нь зүйтэй.

Ер нь бол Засгийн газрын 30 дугаар тогтоол, Ерөнхийлөгчийн 10 дугаар зарлиг, НЗД-ын А/168 дугаар захирамжийн хэрэгжилт ямар байна, одоо байгаа нөхцөл байдал, алдаа дутагдал юу байна, цаашид ямар арга хэмжээ авах, ямар салбарт нэгдэж ажиллах вэ гэдэг талаар голлон ярьсан. Та хоёрт ямар санал, мэдээлэл байна?

**Б.Номинзул /Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн/:**

Нийслэлийн Засаг даргын А/108, А/168 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах үүднээс цаг үеийн холбогдох мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тухай бүрд нь байршуулан ажиллаж байна.

02 дугаар сарын 20-ноос шинэ коронавирусын халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой үүрэг, чиглэл, тогтоол, шийдвэр, захирамжуудын хэрэгжилтийг хангах хүрээнд зохион байгуулагдаж эхэлсэн явган эргүүлийн ажилд хяналт тавьж, өдөр



бүр эргүүлийн тоон мэдээг нэгтгэж дүүргийн Шуурхай штабт тайлагнана, мөн НЗДТГ-ын Шуурхай штабт [ubhealth2020@gmail.com](mailto:ubhealth2020@gmail.com) цахим илгээж байна. Батлагдсан хуваарь ёсоор өнөөдөр Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, дэд бүтцийн инженер Б.Мөнгөнхуяг дүүргийн Шуурхай штабт ажиллаж байгаа.

**Д.Алтангэрэл /Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтэн/:**

Хариуцлагатай жижүүрт гарах нь орой 21:00 цаг хүртэл билүү?

**Б.Номинзул /Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн/:**

Тийм ээ, тухайн өдрийн явган эргүүлийн мэдээг нэгтгээд оройн 21:00 цагт нийслэлийн Эрүүл мэндийн газар руу илгээх юм.

**Ч.Элбэгсайхан /Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын дарга/:**

За ойлгомжтой. Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой хариуцлагатай ажил учир Захиргааны ахлах Б.Номинзул албан хаагчдын хариуцлагатай жижүүрийн ажилд хяналт тавьж, цаг үеийн чанартай мэдээллийг надад илтгэж байгаарай.

**Б.Номинзул /Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн/:**

За ойлголоо.

**Ч.Элбэгсайхан /Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын дарга/:**

Ойрын хугацаанд байгууллагын дүрмийг шинэчлэх шаардлагатай байгаа. Эхний ээлжинд байгууллагын мэргэжилтнүүд дотооддоо дүрмийн төслийг боловсруулна. Боловсруулсан төслийг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт танилцуулах юм.

Байгууллагын үйл ажиллагаагаар 2019 оны эцэс гэхэд одоо байгаа дүрмийн үндсэн зорилтыг хэрэгжүүлж дууссан гэж үзэж байгаа.

Байгууллагын статусын асуудлыг шинэчлэх талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хэлэлцэгдэж байгаа энэ үед бид нар байгууллагын дүрмийг өөрсдийн дараагийн шатны үйл ажиллагаанд тохируулж, өөрөөр хэлвэл, Багануур дүүрэгт Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах бэлтгэл ажил хангагдсан, одоо дэд бүтцийн бүтээн байгуулалтаа эхлүүлж байгаа, дэд бүтээн байгуулалтыг эхлүүлэхтэй зэрэгцээд үндсэн үйл ажиллагаагаа эхлүүлэх суурь тавигдсан учраас үүнтэй нийцүүлж байгууллагын дүрмийг шинэчлэх шаардлага зүй ёсоор гарч ирж байна.

**Д.Алтангэрэл /Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтэн/:**

Тийм шүү, НИТХ-аар 2015 онд батлагдсан байгууллагын дүрэм бол Багануур дүүрэгт Үйлдвэрлэл технологийн паркийг байгуулах бэлтгэл ажлыг хангах буюу паркийн захиргааны зохион байгуулалттай холбоотой байсан. Бид аль хэдийнэ уг дүрмийн дагуу ажлыг гүйцэтгэсэн учир паркийн бүтээн байгуулалт, дэд бүтэцтэй холбогдуулж байгууллагын дүрмийг шинэчлэн боловсруулах хэрэгтэй.

**Ч.Элбэгсайхан /Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын дарга/:**

Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 тоот тушаалын 2 дугаар хавсралтын дагуу БҮТГ-ийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний загварыг стандарт загварт хөрвүүлэх шаардлагатай байна.

2017 онд батлагдсан байгууллагын хөгжлийн дунд хагацааны стратеги төлөвлөгөөний хувьд бидний жил тутмын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлж, шаардлагыг хангаж байгаа учраас өөрчлөлт хийж, шинэчлэх шаардлагагүй гэж үзэж байна.

Тэгэхээр эдгээр ажлуудыг яаралтай зохион байгуулж, ажлын хэсгийг томилъё: Байгууллагын дүрмийг шинэчлэх ажлыг Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн Б.Номинзулаар, Байгууллагын хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг шинэчилсэн загварт хөрвүүлэх ажлыг Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтэн Д.Алтангэрэлээр тус тус ахлуулан нийт хамт олноороо дээрх төслүүдэд хамтарч ажиллая.

**Д.Алтангэрэл /Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтэн/:**

За ойлголоо.



**Ч.Элбэгсайхан /Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын дарга/:**

Дээрх төслүүд бэлэн болсон үед нь даргын зөвлөлийн хурлаар дахин хэлэлцүүлж, дээд шатны байгууллагад хүргүүлэх болно.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Шинэ коронавирусын халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дээд шатны байгууллагаас ирсэн тогтоол, захирамж, шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллах, тайлан мэдээг үнэн зөвөөр бэлтгэн гаргаж холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлж ажиллах


2. Байгууллагын дүрмийг шинэчлэн, найруулах ажлыг эхлүүлэх, БҮТП-ийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг шинэчилсэн загварт хөрвүүлэх ажлыг эхлүүлэх

Хурал 10:15 цагт өндөрлөв.

ХЯНАСАН:

"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК"  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА

Ч.ЭЛБЭГСАЙХАН



ТАНИЛЦСАН:

ҮТА-АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.АЛТАНГЭРЭЛ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ЗА-АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

*Sanvit*

Б.НОМИНЗУЛ